



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/148/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Баасанжаргал Утас: 99032514 Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	17
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.18 № 138
танай _____ -ны № _____ -т

УЛИАСТАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ПҮРЭВГАРЬД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгөөс батлагдсан төсөвтэй байгууллага болон шашны байгууллагад 35.4 сая төгрөгийн дэмжлэг олгосон, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүдэд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар эрх зүйн үндэслэлгүй сумын Засаг даргад хотын захирагчийн нэмэгдэл хөлс гэж үндсэн цалингийн 30 хувиар буюу 4.9 сая төгрөг олгосон, төсвөөс бэлэг дурсгалын зүйлс 1.7 сая төгрөгөөр худалдан авсан, аймгаас эрх шилжиж ирсэн Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хэд хэдэн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн хөрөнгөөр 71.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан байна. Өлзийт багийн жишиг хороолол, дулааны цахилгаан станцын барилгын 34.9 сая төгрөгийн газруудыг үнэлж данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд дуудлага худалдаагаар 129.8 сая төгрөгийн 3 автомашиныг акталсан байна. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 30.4 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хассан байна.

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

81257216

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	<i>/мян.төг/</i>	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	105,507.81	163,644.25
33	АВЛАГА	13,210.00	5,845.80
335	Бусад авлага	13,210.00	5,845.80
3351	Байгууллагаас авах авлага	13,210.00	5,845.80
35	БАРАА МАТЕРИАЛ	92,297.81	157,798.45
351	Түүхий эд материал	2,003.00	-
35110	Тусгай зориулалттай материал	3.00	-
35130	Эм боох материал	2,000.00	-
354	Хангамжийн материал	90,294.81	157,798.45
35410	Бичиг хэргийн материал	4,508.03	5,063.45
35420	Аж ахуйн материал	65,034.32	40,306.61
35430	Сэлбэг хэрэгсэл	7,206.00	1,616.00
35440	Түлш, шатах тослох материал	8,284.51	7,440.00
35450	Барилгын засварын материал	899.00	286.00
35470	Бусад хангамжийн материал	4,362.95	103,086.39
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,210,893.76	2,844,601.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,210,893.76	2,844,601.79
392	Биет хөрөнгө	2,186,680.26	2,786,564.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,466,110.55	2,466,110.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(694,939.25)	(782,369.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	411,134.00	864,735.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(195,021.92)	(107,999.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,064.66	215,232.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,418.75)	(89,697.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,013.33	48,013.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,162.02)	(47,177.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	174,565.25	272,965.25

39215	Хуримтлагдсан элэгдэл	(45,665.60)	(53,246.85)
393	Биет бус хөрөнгө	24,213.50	58,037.33
39301	Программ хангамж	7,362.00	7,802.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,644.50)	(4,136.17)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,496.00	54,371.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,316,401.57</u>	<u>3,008,246.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,000.00	-
413	Өглөг	5,000.00	-
4136	Бусад өглөг	5,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	5,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,311,401.57</u>	<u>3,008,246.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,311,401.57	3,008,246.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	317,322.28	317,322.28
51101	Өмч: - төрийн	317,322.28	317,322.28
512	Хуримтлагдсан үр дүн	1,647,884.37	2,344,728.84
51210	Өмнөх үеийн үр дүн	1,647,884.37	1,647,884.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	696,844.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	346,194.92	346,194.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,316,401.57</u>	<u>3,008,246.04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,843,291.21	4,395,509.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,504,488.19	820,528.94
120	Нийтлэг татварын бус орлого	3,504,488.19	820,528.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,504,488.19	820,528.94
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,233,240.22	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	271,247.97	820,528.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,338,803.02	3,574,980.18

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,283,391.55
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,260,577.68
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	22,813.87
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,338,780.60	2,224,885.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,338,780.60	2,224,885.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	66,703.63
1330	Төсвийн захирагчдаас	-	66,703.63
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22.42	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22.42	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,545,966.52	3,698,664.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,545,966.52	3,698,664.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,456,938.71	3,477,246.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	919,140.97	1,333,851.46
210101	Үндсэн цалин	596,176.12	852,630.20
210102	Нэмэгдэл	220,038.02	400,146.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,175.33	57,809.64
210104	Урамшуулал	64,751.50	23,264.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,230.10	166,944.60
210201	Тэтгэврийн даатгал	78,356.40	113,522.20
210202	Тэтгэмжийн даатгал	9,218.40	13,355.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,374.80	8,452.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,843.70	4,903.50
210205	Эрүүл мэндийн даатгал	18,436.80	26,711.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,706.65	147,806.25
210301	Гэрэл, цахилгаан	25,310.86	14,132.92
210302	Түлш, халаалт	86,108.78	127,544.14
210303	Цэвэр, бохир ус	4,287.01	6,129.19
2104	Хангамж, бараа материалын зардал	56,070.14	109,269.17
210401	Бичиг хэрэг	7,413.32	9,473.54
210402	Тээвэр, шатахуун	36,007.29	53,931.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,649.53	15,496.12

210408	Бараа материал акталсны зардал	-	30,368.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,619.83	13,766.10
210604	Урсгал засвар	11,619.83	13,766.10
2107	Томилолт, зочны зардал	4,527.70	5,434.30
210702	Дотоод албан томилолт	4,527.70	5,434.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,210.14	3,440.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,962.70	2,381.55
210803	Даатгалын үйлчилгээ	250.86	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195.75	221.68
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64.59	66.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600.40	164.01
210807	Газрын төлбөр	135.85	138.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,224,433.17	1,696,734.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,111,953.38	1,513,356.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	303.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,479.79	183,074.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,027.81	221,417.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,460.90	148,154.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,460.90	75,371.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	72,183.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	71,566.91	73,263.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,566.91	73,263.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>297,324.69</u>	<u>696,844.46</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>297,324.69</u>	<u>696,844.46</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,571,143.25	3,574,980.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,232,340.22	-
120	Нийтлэг татварын бус орлого	3,232,340.22	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,232,340.22	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,232,340.22	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,338,803.02	3,574,980.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,283,391.55
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,260,577.68
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	22,813.87
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,338,780.60	2,291,588.63
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,338,780.60	2,224,885.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	66,703.63
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22.42	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22.42	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,452,058.25	3,503,962.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,452,058.25	3,503,962.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,363,030.44	3,282,545.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	919,140.97	1,333,851.46
210101	Үндсэн цалин	596,176.12	852,630.20
210102	Нэмэгдэл	220,038.02	400,146.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,175.33	57,809.64
210104	Урамшуулал	64,751.50	23,264.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,230.10	166,944.60
210201	Тэтгэврийн даатгал	78,356.40	113,522.20
210202	Тэтгэмжийн даатгал	9,218.40	13,355.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,374.80	8,452.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,843.70	4,903.50
210205	Эрүүл мэндийн даатгал	18,436.80	26,711.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,865.95	147,806.25

210301	Гэрэл, цахилгаан	12,688.36	14,132.92
210302	Түлш, халаалт	98,731.28	127,544.14
210303	Цэвэр, бохир ус	4,446.31	6,129.19
2104	Хангамж, бараа материалын зардал	63,701.73	71,420.54
210401	Бичиг хэрэг	8,740.40	10,240.20
210402	Тээвэр, шатахуун	42,311.80	45,684.23
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,649.53	15,496.12
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,027.80	11,859.10
210604	Урсгал засвар	14,027.80	11,859.10
2107	Томилолт, зочны зардал	4,527.70	5,434.30
210702	Дотоод албан томилолт	4,527.70	5,434.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,520.61	3,289.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,241.21	2,192.25
210803	Даатгалын үйлчилгээ	250.86	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	221.68
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64.59	66.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600.40	202.51
210807	Газрын төлбөр	135.85	138.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,119,015.58	1,541,939.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,118,712.18	1,541,635.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,027.81	221,417.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,460.90	148,154.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,460.90	75,371.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	72,183.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	71,566.91	73,263.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,566.91	73,263.17

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>119,085.00</u>	<u>71,017.40</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	119,085.00	71,017.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,085.00	71,017.40
2200	Дотоод эх үүсвэрээр	119,085.00	71,017.40
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	119,085.00	71,017.40
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(119,085.00)</u>	<u>(71,017.40)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,322.28	346,194.92	1,647,884.37	-	2,311,401.57
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	317,322.28	346,194.92	1,647,884.37	-	2,311,401.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,322.28	346,194.92	1,647,884.37	-	2,311,401.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-

D08	Тайлант үеийн үр дүн	-	-	696,844.46	-	696,844.46
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,322.28	346,194.92	2,344,728.84	-	3,008,246.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,224,885.00	2,210,909.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,224,885.00	2,210,909.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,071,279.80	2,063,354.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,335,554.70	1,333,851.46
210101	Үндсэн цалин	989,726.30	852,630.20
210102	Нэмэгдэл	345,828.40	400,146.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	57,809.64
210104	Урамшуулал	-	23,264.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,944.50	166,944.60
210201	Тэтгэврийн даатгал	113,522.10	113,522.20
210202	Тэтгэмжийн даатгал	13,355.70	13,355.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,452.20	8,452.20
210204	Ажилгүйдлийн даатгал	4,903.50	4,903.50
210205	Эрүүл мэндийн даатгал	26,711.00	26,711.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,278.20	147,806.25
210301	Гэрэл, цахилгаан	19,462.20	14,132.92
210302	Түлш, халаалт	122,258.00	127,544.14
210303	Цэвэр, бохир ус	7,558.00	6,129.19
2104	Хангамж, бараа материалын зардал	70,352.60	69,640.34
210401	Бичиг хэрэг	10,240.60	10,240.20
210402	Тээвэр, шатахуун	44,712.60	43,904.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,399.40	15,496.12
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,027.80	82,876.50

210601	Багаж, техник, хэрэгсэл	71,000.00	70,848.70
210604	Урсгал засвар	12,027.80	12,027.80
2107	Томилолт, зочны зардал	4,527.70	4,519.50
210702	Дотоод албан томилолт	4,527.70	4,519.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,821.60	2,297.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	693.60	-
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	221.68
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73.80	66.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	202.51
210807	Газрын төлбөр	138.30	138.16
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	259,772.70	255,418.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	259,469.30	255,115.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,605.20	147,554.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,605.20	147,554.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,371.60	75,371.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	78,233.60	72,183.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,000,846.30	2,224,885.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,777,846.30	2,224,885.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,777,846.30	2,224,885.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	223,000.00	66,703.63
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	223,000.00	66,703.63
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	54	63
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	22	23
620003	Үйлчлэх ажилтан	23	2

620004	Гэрээт ажилтан	-	29
--------	----------------	---	----

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,290,807.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,290,807.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,207.92
2104	Хангамж, бараа материалын зардал	1,780.20
210402	Тээвэр, шатахуун	1,780.20
2107	Томилолт, зочны зардал	914.80
210702	Дотоод албан томилолт	914.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	992.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	992.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,286,520.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,286,520.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,283,391.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,283,391.55
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,260,577.68
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,813.87

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн

төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй тэгш, шударга, үр нөлөөтэй хүргэж хөгжлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжүүлэх” гэсэн зорилгын хүрээнд 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 19 зорилт 137 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн 96.7 хувиар үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улиастай сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 691,844.4 мянган төгрөгөөр буюу 29.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	13,210.0	5,845.8	(7,364.2)
Бараа материал	92,297.8	157,798.4	65,500.6
Үндсэн хөрөнгө	2,210,893.7	2,844,601.7	633,708.0
Нийт хөрөнгө	2,316,401.5	3,008,245.9	691,844.4
Өр төлбөр	5,000.0	-	(5,000.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,311,401.6	3,008,246.0	696,844.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,316,401.6	3,008,246.0	691,844.4

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Авлага данс 7,364.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 5,845.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан, бараа материал өмнөх оноос 65,500.6 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал дансанд 44,692.2 мянган төгрөгийн өвс тэжээл, 18,138.4 мянган төгрөгийн сонгуулийн самбар, саналын хайрцаг зэргийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Харин үндсэн хөрөнгө данс 633,708.0 мянган төгрөгөөр өссөн нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч, хандиваар бүртгэсэн 596,900.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 15,590.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 68,000.0 мянган төгрөгийн лед дэлгэц, 30,400.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгөөр, 34,875.5 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө зэргийг орлогод авсан, мөн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр худалдан авсан 71,017.4 мянган төгрөгийн суурин компьютер, өнгөт принтер, зөөврийн компьютер зэргийг худалдан авсан, тайлант оны элэгдлийн зардалд 183,074.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ 696,844.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 1,980,518.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 20,327.6 мянган төгрөгөөр, нийт 2,000,846.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 224,039.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 6 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 2,224,885.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,224.885.0 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 66,703.6 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, гүйцэтгэл 2,210,909.1 мянган төгрөг буюу 99.4 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 13,975.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,090,463.7	1,086,033.5	4,430.2	99.6
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил	476,985.5	475,554.1	1,431.4	0.0
3	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	260,589.6	256,731.4	3,858.2	98.5
4	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	1,200.0	-	0.0
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	147,554.6	147,554.6	-	0.0
6	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	225,000.0	220,743.9	4,256.2	98.1
7	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	23,091.6	23,091.6	-	100.0
		Дүн	2,224,885.0	2,210,909.1	13,975.9	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 1,283,391.5 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 923,681.2 мянган төгрөг, аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 73,800.4 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас 261,626.0 мянган төгрөг, Улиастай сумын Орон нутгийн

хөгжлийн сангаас 1,470.0 мянган төгрөг, өөрийн орлого 22,813.9 мянган төгрөгөөс тус тус бүрдсэн байна.

Үүнийг аймгаас эрх шилжин хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудад 1,196,664.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд шатахуун, томилолт болон бусад зардлуудад үлдэгдлийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 59,287.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих төсөвт өртөг	Шалгаруулалтын арга
1	Улиастай сумын цэвэр, бохир усны шугамыг хэсэгчилж засварлах ажил	120,000.00	117,424.63	Харьцуулалтын арга
2	Атмор байрны хайсыг чөлөөлж, Жинст төгөл хүртэл авто зогсоол хийх	73,500.00	70,803.14	Харьцуулалтын арга
3	Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албанд хогны машин авах	90,000.00	85,700.00	Харьцуулалтын арга
4	Улиастай сумын дөрөвдүгээр сургуульд цахим танхим байгуулах	50,000.00	47,650.00	Харьцуулалтын арга
5	Улиастай сумын сургуулиудын ойр орчмын авто зам дээр Лед гэрэлтүүлэгтэй явган хүний гарц хийх	37,200.00	35,959.62	Харьцуулалтын арга
6	Улиастай сумын тавдугаар цэцэрлэгийн барилгын гадна дулааны шугамыг шинэчлэх	32,000.00	31,362.05	Харьцуулалтын арга
7	Холбооны 27-р байрны баруун талд авто зогсоол хийх	33,500.00	32,132.03	Харьцуулалтын арга
8	Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн дотуур байранд шаардлагатай тоног төхөөрөмж авах	39,000.00	36,900.00	Харьцуулалтын арга
9	Үндэсний сурын талбайг нэмж тохижуулах	67,400.00	67,300.44	Харьцуулалтын арга
Дүн		542,600.00	525,231.90	

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 3/44 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийн нийт орлого 1,617,183.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,257.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар материаллаг байдлыг сонгосон тул, гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогын 4,395,509.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 65,932.6 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд гэрэл цахилгааны зардлыг 5,329.3 мянган төгрөг, цэвэр бохир усыг 1,428.8 мянган төгрөг, тээвэр шатахууныг 808.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор (shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг шалгахад худалдан авах ажиллагааны тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэргийг мэдээлээгүй байна. Бусад үзүүлэлтээр мэдээлсэн байдлын хэрэгжилт 90.1 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрсэн байна. Эд хариуцагч үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй, тайлан ирүүлээгүй, нягтлан бодогч эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед ажил хүлээлцэж хөрөнгийг шилжүүлдэггүй, байгууллагын дотоод хяналтын нэгж байгуулан 2024 онд төлөвлөгөө боловсруулан батлуулсан ч, хяналт шалгалт хийгээгүй зэрэг зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Мөн хяналтын тооллогоор 1,285.4 мянган төгрөгийн бараа материалын дутагдалд төлбөрийн акт тогтоосон байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 125,000.8 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж, 53,993.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 825.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна. Хэрэгжилт 96.6 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	825.0	1	825.0	100
Албан шаардлага	1	53,993.6	1	53,993.6	100
Зөвлөмж	3	125,000.8	2	125,000.8	90
Нийт дүн	5	179,819.4	4	179,819.4	96.6

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,790.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 26,790.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Модны суулгацыг бараа материал дансаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан 26,790.0 мянган төгрөгийн алдаа гаргасан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 447,059.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 400,689.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 45,300.0 мянган төгрөгийн зөвлөмж, 1,070.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Төсвөөс 1,070.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан.

5.2 Албан шаардлага

1. Орон нутгийн замын сангийн санхүүжилтээр "Эко эвсэг зам" ХХК-ийн гүйцэтгэсэн 79.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нутгийн удирдлагын ордны зүүн талын зогсоолыг засварлах ажил 2023-2024 онуудад үргэлжилсэн боловч гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, санхүүжилтийг бүрэн олгож, тайлант онд 12.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон;

2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 300.0 сая төгрөгөөр төлөвлөгдөж эрх шилжсэн "Жалханз хутагт Ц.Дамдинбазар"-ын 150 жилийн ойд зориулж дурсгалын цогцолбор, хөшөө байгуулах ажлын гэрээний дүнг 440.7 сая төгрөгөөр иргэн н.Ганхуягтай байгуулан ажлыг хийж гүйцэтгэхээр байгуулсан гэрээний хугацаа дууссан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, ажил хүлээлцээгүй, тайлант онд 275.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон;

3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр эрх шилжсэн "Энх мөнх ирээдүй" ХХК-ийн гүйцэтгэсэн 89.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэргийн ангийн баруун талаас зүүн чиглэлийн пост хүртэлх явган замыг шинэчлэх" ажил 2023-2024 онуудад үргэлжилсэн бөгөөд тайлант онд 28.0 сая төгрөгийг шилжүүлсэн, гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, захиалагчийн хяналт

хэрэгжүүлсэн ч зураг төсөв, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгээгүйн улмаас ажлыг хүлээлгэн өгөөгүй;

4. Аймгийн Засаг даргын 2024 оны А/59 дүгээр захирамжийн дагуу “Дуртмал-Алтан” ХХК-д 44.0 сая төгрөгийг шилжүүлэн 1000 хүний хүлээн авалтыг зохион байгуулан, төсвөөс зориулалт бус, үрэлгэн зардал гаргасан байна.

5. Засаг даргын нөөц хөрөнгөөс өөрийн батлагдсан төсөвтэй байгууллагуудад 25.4 сая төгрөгийн, Төгс буянт жавхланта хийдэд 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон;

6. Сумын Засаг даргад хууль, эрх зүйн үндэслэлгүй "хотын захирагчийн нэмэгдэл хөлс" хэмээн үндсэн цалингийн 30 хувиар тооцон 4.9 сая төгрөг олгосон;

7. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Фамили партнерс ХХК, Төгс үржих зам ХХК, Тэсийн зам ХХК болон иргэний гүйцэтгэсэн богдын голын далан засах, замын нөхөөс, явган хүний зам засварлах ажлуудын санхүүжилтийг гэрээнд заасан дүнгээр олгоогүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй, санхүүжилтийг бөөн дүнгээр олгосон, өртөг зардлын тооцоо хийгдээгүй 45.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, 7.1.3.11, мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.2.4-д "төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шууд гэрээ байгуулан төсвийн хөрөнгөөс санхүүжүүлсэн ажлуудын ажлын даалгаврыг тодорхой болгон гүйцэтгэгч компанитай гэрээг сунган, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэн, ажлыг хүлээн авах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Модны суулцацыг бараа материал дансаар дамжуулаагүй, шууд зардлаар тайлагнасан	1	26,790.0	0	-	1	26,790.0	1	26,790.0	0	0		
Дүн	1	26,790.0	-	-	1	26,790.0	1	26,790.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төгбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шийгжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгөөс өөрийн батлагдсан төсөвтэй байгууллагуудад 25.4 сая төгрөгийн, Төгс буянт жавхлантай хийдэд 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон	1	35,403.8			1	35,403.8						
Сумын Засаг даргад хууль, эрх зүйн үндэслэлгүй "хотын захирагчийн нэмэгдэл хөлс" хэмээн үндсэн цалингийн 30 хувиар тооцон 4.9 сая төгрөг олгосон	1	4,939.1			1	4,939.1						
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар газрыг үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй	1	-			1	-						
Орон нутгийн замын сангийн санхүүжилтээр "Эко зэвсэг зам" ХХ-ийн гүйцэтгэсэн 79.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нутгийн удирдлагын ордны зүүн талын зогсоолыг засварлах ажил 2023-2024 онуудад үргэлжилсэн боловч гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, санхүүжилтийг бүрэн олгож, тайлант онд 12.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон;	1	12,846.8			1	12,846.8						
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 300.0 сая төгрөгөөр төлөвлөгдөж эрх шилжсэн "Жалханз хутагт Ц.Дамдинбазар"-ын 150 жилийн ойд зориулж дурсгалын цогцолбор, хөшөө байгуулах ажлын гэрээний дүнг 440.7 сая төгрөгөөр иргэн н.Ганхуянтай байгуулан ажлыг хийж гүйцэтгэхээр байгуулсан гэрээний хугацаа дууссан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, ажил хүлээлцээгүй, тайлант онд 275.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон	1	275,500.0			1	275,500.0						
Аймагас эрх шилжиж ирсэн 89,949,865 төгрөгийн төсөвт өртөгтэй "Энх мөнх ирээдүй" ХХ-н гүйцэтгэсэн "Цэргийн ангийн баруун талаас зүүн чиглэлийн пост хүртэлх явган замыг шинэчлэх" ажил 2023, 2024 онуудад үргэлжилсэн бөгөөд гэрээний хугацаа дууссан, ажил хүлээлцээгүй, санхүүжилтийг бүрэн олгосон	1	28,000.0			1	28,000.0						
Аймгийн Засаг даргын 2024 оны А/59 дүгээр захирамжийн дагуу "Дуртмал-Алтан" ХХ-д 44.0 сая төгрөгийг шилжүүлэн 1000 хүний хүлээн авалтыг зохион байгуулан, төсвөөс зориулалт бус, үрэлгэн зардал гаргасан байна.	1	44,000.0			1	44,000.0						
Шууд гэрээ байгуулсан ажлуудын санхүүжилтийг гэрээнд заасан дүнгээр олгоогүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй, санхүүжилтийг бөөн дүнгээр олгосон, өртөг зардлын тооцоо хийгээгүй	1	45,300.0					1	45,300.0				
Төсвөөс бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан	1	1,070.0	1	1,070.0								
Дүн	9	447,059.7	1	1,070.0	7	400,689.7	1	45,300.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2025.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.БОЛДБААТАР

2025.02.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Г.БААСАНЖАРГАЛ

2025.02.25